



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 11 өдөр

Дугаар A/62

Жаргалтхаан

**Гэрээ байгуулж, санхүүжилтийн
эрх олгох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 59 дүгээр зүйлийн 59.1.4, 59.1.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, 28 дугаар зүйлийн 28.1.1, 34 дүгээр зүйлийн 34.9, 48 дүгээр зүйлийн 48.2.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын 2024 оны Орон нутгийн хөгжлийн сангийн 29,997,000 (хорин есөн сая есөн зуун ерэн есөн мянган) төгрөгийн хөрөнгөөр хийгдэх “Камержуулалт нэмэгдүүлэх” ажлын гэрээг “ХСТТ” ХХК-тай байгуулж санхүүжүүлэх эрх олгосугай.

2. Ажлын гүйцэтгэлийг харгалзан санхүүжилтийг олгохоор гэрээ байгуулан батлуулах, гэрээний хэрэгжилтийг хангуулж, ажлыг чанартай гүйцэтгүүлэн тайлагнаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (С.Мөнхдэлгэр)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (С.Ганбат)-д даалгасугай.

ДАРГА



Л.ЦЭНГЭЛ